



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-6</i>

1.Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудал

4-6

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 05 дугаар сарын 02-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ж.Батсуурь, Ё.Баатарбилэг, Ц.Мөнх-Оргил, Г.Занданшатар, Л.Оюун-Эрдэнэ, Д.Сарангэрэл, Ж.Эрдэнэбат.

Нэг.Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлд нэр дэвшигч Н.Монсор, Ж.Золзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатангуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд танилцуулав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд Нэр дэвшигчийн сонсгол болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар санал хураалтыг нууцаар явуулах горимтой тул Байнгын хорооны хуралдааныг хаалттай явуулъя гэсэн горимын санал гаргав.

Н.Энхболд: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг 14 цаг 52 минутад хаалттай горимд шилжүүлэв.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 37 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 15 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин
Д.Сүхбаатар” танхим 14 цаг 45 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Хуралдаанд оролцож байгаа
Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ
энэ өдрийн мэнд хүргэе.

Гишүүдийн олонх хүрэлцэн ирж,
ирц бүрдсэн байна. Ингээд Төрийн
байгуулалтын байнгын хорооны 2023 оны
5 сарын 2-ны өдрийн хуралдаан нээснийг
мэдэгдье ээ. Байнгын хорооны
хуралдаанаар өнөөдөр МҮОНРТ-ийн
Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх
гишүүнээр томилох тухай асуудал ярина,
төлөвлөсөн.

Хэлэлцэх асуудал дээр саналтай
гишүүн байна уу? Алга байна.

МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн
гишүүнээс чөлөөлөх гишүүнээр томилох
асуудлыг хэлэлцье. Хуулийн дагуу Их
Хурлын дэгийн тухай хуулиар 127.1-д
зааснаар ажлын 5 өдөр дотор энэ
ажиллагаа хийх ёстой. Эрх бүхий
этгээдийн санал сонсголын тайланг
Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн
шагнал санал, дүгнэлт гаргах ёстой урьд
нь бид нар сонсголоо хийсэн,
сонсголынхоо тайланг сонссон. Тэрэн
дээр бас санал хураагаад материалуудыг
тараачихсан байгаа. Гишүүд танилцсан
байх гэж бодож байна. Ингээд сонсголын
тайланг ажлын хэсгийн гишүүн Улсын Их
Хурлын гишүүн Ганболд танилцуулна.

Г.Ганболд: Байнгын хорооны
дарга, эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн радио, телевизийн
үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч
нартай хийсэн нэр дэвшигчийн сонсголыг
Олон нийтийн радио телевизийн тухай

хуулийн 26 дугаар зүйлд 21.6 Үндэсний
зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар эдийн
засаг, бизнес, техник технологи,
удирдлага, менежментийн чиглэлээр үйл
ажиллагаа явуулдаг төрийн бус
байгууллагууд тухайн чиглэлээр
мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт
тус тус санал болгоно, 21.7 энэ хуулийн
21.5-д заасан байгууллага, албан
тушаалтан, төрийн бус байгууллагуудын
саналаас сонголт хийн Үндэсний
зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж Улсын
Их Хуралд өргөн мэдүүлнэ. 21.8-д энэ
хуулийн 21.7-д заасны дагуу нэр дэвшсэн
хүмүүсийг Улсын Их Хурал нэр
дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр
хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр
томилно гэж заасны дагуу Монгол Улсын
Их Хурлын хяналт шалгалтын тухай
хуулийн 31 дүгээр зүйлийн нэр дэвшигчийн
сонсголыг үе шатыг баримтлан дараах
ажиллагаа явууллаа.

1.Монгол Улсын Засгийн газар
Монголын менежментийн манлайлал
форум нийтэд үйлчлэх ТББ-аас нэр
дэвшүүлсэн Нямдаваагийн Монсор
Монгол улсын Засгийн газар Монголын
Үндэсний Маркетингийн холбооноос нэр
дэвшүүлсэн Жаргалсайханы Золзаяа нар
нь Төрийн байгуулалтын байнгын хорооны
2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан
нэр дэвших тухай хүсэлтийн загварын
дагуу материалаа бүрдүүлж 2023 оны 1
дүгээр сарын 16-нд Байнгын хороонд
ирүүлсэн болно.

2023 оны 3 дугаар сарын 21-ний
өдрийн Байнгын хорооны хуралдаанаар
Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуулийн 119
дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг Монгол
Улсын Их Хурлын хяналт шалгалтын
тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т
заасны дагуу нэр дэвшигчийн сонсголын
товыг тогтоох, сонсгол даргалагчийг
томилох тухай тогтоолыг баталж 2023
оны 4 дүгээр сарын 24-ний өдөр нэр
дэвшигчийн сонсгол зохион байгуулахаар
сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын

гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилигийг томилсон.

3. Сонсголын бэлтгэл хангах хүрээнд нэр дэвшигчийн мэдээллийг *parliament.mn* буюу Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчийг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас *itoim.mn*, *ikon.mn*, *24 tsag.mn*, *livetv.mn* *eguir.mn*, *news.mn*, *newspress.mn*, *times.mn*, *tovch.mn*, *zarig.mn*, *MGL 88.3 FM* радио зэргээр 32 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан мэдээллийн дагуу нэг ажиглагч бүртгүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан. Огноо, цаг, минутаар бүртгэн баталгаажуулсанб

4. 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр өдрийн 15 цагт Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн 1/3-ээс доошгүй нь хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд Байнгын хорооны хуралд Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилиг, С.Бямбацогт, Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, Д.Сарангэрэл, Ж.Сүхбаатар, Н.Энхболд нар хүрэлцэн ирж ирц бүрдэж нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүдийн сонсгол явуулснаас хойш 2 өдрийн дотор хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргана. Тайлан сонсголын дүнд үндэслэн тухайн нэр дэвшигч албан тушаалд шаардлага хангасан эсэх дүгнэлт түүний үндэслэлийг тусгана. Тухайн тайланг ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигч түүний санал болгосон этгээдэд хүргүүлж парламентын цахим хуудаст байршуулах болно гэсний дагуу 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон

гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж нэр дэвшигч Монсоныг ажлын хэсгийн тайлан ирүүлсэн материал болон сонсголын үр дүнг үндэслэн Олон нийтийн радио төлөвлөлтийн үндэсний зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр, нэр дэвшигч Ж.Золзаяаг гишүүдийн олонх дэмжлээ. Монгол Улсын Их Хуралд олон нийтийн радио телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд санал болгосон нэр дэвшигчийн талаарх сонсголын тайланг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Ажлын хэсэг танилцуулъя өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа. ЗГХЭГ-ын дэд дарга Баасандорж мөн Газрын салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Мөнхцэрэн, нэр дэвшигч Золзаяа, Монсор нар ирсэн байна аа.

Хуралдааны дэгийн тухай хуулиар энэ асуудлыг хаалттай хэлэлцэх ёстой. Ажлын хэсэг хаалттай хэлэлцсэн. Ажлын хэсгийн тайлангаа бид бас хаалттай сонссон. Чуулганы нэгдсэн хуралдаанаар нууц хаалттай хэлэлцэж нууцаар санал хурааж шийдэх ёстой.

Тэгэхээр Байнгын хорооны хурлаа ч гэсэн хаалттай хийгээд санал хураалтаа нууцаар хийнэ ээ. Хаалттай дэглэмд оруулъя. Асуулт асууна, хариулт өгнө. Тийм учраас урьд нь явсан дэгээрээ явчихъя.

Болсон уу? Болохоор байна уу? Санал хураана шүү. Энэ хуулийн зохицуулалтаар бол нөгөө сонсгол дээр чуулган дээр хоёулаа хаалттай тэгээд нууцаар санал хураах юм байна лээ. Яг Байнгын хорооных дээр бол энэ зохицуулалт юм нь үг үсгээрээ байхгүй юм

байна лээ. Гэхдээ нэгэнт хойно урьд хойно нь явж байгаа хоёр бол хоёулаа нууцаар санал хурааж явж байгаа учраас Байнгын хорооныхоо хуралд үг хэлэх, асуух, санал хураахаа нууцаар хаалттай явуулъя гээд зарчмаараа санал хураачихъя.

Нэг хүн хэрэгтэй байна даа. Тогтохсүрэн дарга ойрхон байж байгаадаа одоохон дуудчихъя гэсэн.

Саяын горимын саналаараа санал хураачихъя гишүүд ээ.

Хуралдаанаа хаалттай явуулаад, санал хураахаа нууцаар шийдвэрлэнэ гэдэг дээр санал хураалт.

Горимоороо санал хураачихъя.

Санал хураалт. 11 гишүүн оролцож, 6 дэмжиж 54.5 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалтаа, хэлэлцүүлгээ нууцаар явуулна. Горимын санал дэмжигдлээ.

15:22

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА